



МОНГОЛ УЛС  
ЁС ЗҮЙН ХОРООНЫ  
ТОГТООЛ

2025 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Ёс зүйн хорооны 2025-2028 оны  
стратеги төлөвлөгөө батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэг, Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын Байнгын хорооны 2023 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрэм”-ийн 3.1, 3.5 дахь хэсэг, Засгийн газрын “Журам батлах тухай” 2020 оны 216 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ёс зүйн хорооны 2025-2028 оны стратеги төлөвлөгөө”-г хавсралт ёсоор баталсугай.

2. Ёс зүйн хорооны 2025-2028 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Ажлын алба (Н.Ганбаатар)-д даалгасугай:

1/Стратеги төлөвлөгөөний зорилт, арга хэмжээг Улсын хөгжлийн төлөвлөгөө болон жил бүрийн улсын төсөвт тусган хэрэгжүүлэх;

2/Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүр гарган, үр дүнг тооцож тухайн оны 12 дугаар сард багтаан танилцуулах.

ДАРГА



Ц.АМАРТӨГС

152501002

Ёс зүйн хорооны 2025 оны 01  
дүгээр сарын 13 өдрийн 01  
дүгээр тогтоолын хавсралт

ATA11169 8448906  
902311371

## ЁС ЗҮЙН ХОРООНЫ 2025-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

### Ёс зүйн хорооны чиг үүрэг

Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр бусад хууль, тогтоомжоор олгогдсон бүрэн эрх, нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

### Алсын хараа

Ёс зүйт төрийн албыг манлайлна.

### Эрхэм зорилго

Хариуцлагатай, тэгш, хүртээмжтэй, итгэл даах зарчмыг хэвшүүлсэн, суралцагч ёс зүйт төрийн албыг хөгжүүлнэ.

### Үнэт зүйл

- Энэрэнгүй байх;
- Хүндэтгэлтэй байх;
- Оролцоотой байх;
- Ил тод, нээлттэй байх;
- Санаачлагч байх.

**Стратегийн зорилго 1:** Ёс зүйт төрийн албыг төлөвшүүлэхэд төр, иргэн, олон нийт, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагын хамтын ажиллагаа, түншлэлийг өргөжүүлж, үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлнэ.

**Стратегийн зорилт 1.1.** Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг бууруулах замаар зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг идэвхжүүлнэ.

### Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх нөлөөллийн үйл ажиллагааг байгууллага<sup>1</sup> манлайлан, иргэн, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах;

<sup>1</sup> "байгууллага" гэснийг Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан этгээд, тэдгээрийг харьяалах байгууллагыг хамааруулан ойлгоно.

2. Шударга, зөв, ёс зүйтэй байх үзэл, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн сэдэв, агуулга бүхий нөлөөллийн ажлыг иргэний нийгэм, олон нийт, төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран үе шаттайгаар хэрэгжүүлэх;

3. Төрийн албан хаагч иргэн, олон нийтэд үлгэрлэх, нийгмийн сайн сайхныг нөлөөлөгч байх бодлого, үйл ажиллагааг өргөжүүлэх.

#### **Хүрэх үр дүн:**

1. Төрийн албан хаагчдыг соён гэгээрүүлэх, нөлөөллийн ажлын үр нөлөө дээшилж, зөрчилд өртөх эрсдэл буурсан байна.

**Стратегийн зорилт 1.2. Төрийн албаны ёс зүйн талаар ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлж, төрийн болон төрийн бус байгууллага, судалгаа шинжилгээний байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэн хамтран ажиллана.**

#### **Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

1. Төрийн албан хаагчдад ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх сургалт, хэлэлцүүлэгт олон талын оролцоог хангаж, мэдээллийг нийтэд хүртээмжтэй хүргэх;

2. Төрийн албаны ёс зүйн хэм хэмжээ, практик зөвлөмжүүдийг нээлттэй, ашиглахад хялбар байдлаар гаргаж, цахим хуудас, мэдээллийн хэрэгслүүдээр нийтэд түгээх;

3. Ёс зүйг хөндсөн асуудал, нийтлэл, нэвтрүүлэг, ярилцлагуудыг зохион байгуулж, төрийн албан хаагчдад ёс зүйн боловсрол, мэдлэг олгох, ёс зүйт төрийн албыг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээллийг олон нийтэд хүргэх давтамжийг нэмэгдүүлэх.

#### **Хүрэх үр дүн:**

1. Төрийн албаны ёс зүйн хууль тогтоомж хэрэгжиж төр, иргэний нийгэм, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагын хамтын ажиллагаа, түншлэл нэмэгдэж, ёс зүйт төрийн алба төлөвших нөхцөл бүрдэнэ.

**Стратегийн зорилго 2: Төрийн албан хаагчийн ёс зүйтэй ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлж, олон нийтийн хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлнэ.**

**Стратегийн зорилт 2.1. Ёс зүйн чиглэлээр судалгаанд суурилсан бодлого, шийдвэр гаргахад дүн шинжилгээ, тоон мэдээллээр хангана.**

#### **Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

1. Төрийн албан дахь ёс зүйн асуудал ба зөрчлийн талаарх олон нийтийн санаа бодлыг тандах, төлөв байдлыг тодорхойлох судалгааг жил бүр зохион байгуулж, зөрчлийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох, үр дүнг бодлого үйл ажиллагаандаа тусгаж ашиглах, эрсдэлийг бууруулах;

2. Төрийн албан хаагчийн ёс зүйн төлөв байдал, түүнд гарч буй өөрчлөлтийг судалж, судалгаа шинжилгээ, хяналт, үнэлгээний ажилд хувийн хэвшил, иргэний

нийгэм, хэвлэл мэдээлэл, судалгааны байгууллага, мэргэшсэн баг, судлаачийн оролцоог хангах;

3. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг баталж, бодлогын хэрэгжилтийн үр дүнг жил бүр үнэлж, үр дүнг тооцно.

#### **Хүрэх үр дүн:**

1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд нөлөөлөх хүчин зүйлийг тогтмол судалж, дүн шинжилгээ хийж, үр дүнг олон нийтэд нээлттэй тайлагнаж, хяналт-шинжилгээний үр дүнг бодлого, шийдвэрт туссан байна.

**Стратегийн зорилт 2.2. Судалгаа шинжилгээний үр дүнд суурилсан ёс зүйн эрсдэлийг тооцох үнэлгээ, ёс зүйн индекс, манлайллын шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулж, нэвтрүүлнэ.**

#### **Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

1. Төрийн албаны ёс зүйн индексийг үндэсний үнэт зүйл, онцлог, олон улсын жишиг, стандарт, нийтлэг хандлагад нийцүүлэн судалж, үе шаттай нэвтрүүлэх;

2. Төрийн албан хаагчийн ёс зүй, шударга байдлын төлөвшилд өөрийн болон хамт олон, удирдлага, иргэн, үнэлгээ өгөх хөндлөнгийн үнэлгээний тогтолцоог бий болгох;

3. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг байгууллага бүр хөндлөнгийн оролцогчид, байгууллагатай хамтран гүйцэтгэж, төрийн албаны ёс зүйн зөрчлийн эрсдэл түүний шалтгаан, нөхцөл байдлын талаар олон нийтэд мэдээлэх.

#### **Хүрэх үр дүн:**

1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээ, ёс зүйн индекс, төрийн өндөр болон томилох эрх бүхий албан тушаалтанд тавигдах ёс зүйн манлайллын шалгуур үзүүлэлтийг иргэний нийгмийг оролцуулан боловсруулж, хэрэгжүүлж эхэлсэн байна.

**Стратегийн зорилго 3: Төрийн албан хаагчийн ёс зүйн хариуцлагын тогтолцоог хөгжүүлнэ.**

**Стратегийн зорилт 3.1. Ёс зүйн дэд хороо, томилох эрх бүхий албан тушаалтанд хууль, эрх зүйн зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулж, хяналттайгаар хэрэгжүүлнэ.**

#### **Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

1. Ёс зүйн дэд хороо, томилох эрх бүхий албан тушаалтанд хууль, эрх зүйгээр зөвлөн тусалж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хамтын ажиллагааг өргөжүүлэх;

2. Ёс зүйн зөрчлийн бүртгэл хөтлөх, мэдээллийн цахим санг баяжуулж, олон нийтэд мэдээлэх, ёс зүйн дэд хороодын мэдээлэл солилцох дэд бүтцийг бий болгон холбогдох хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах;

3. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд нийцүүлэн ёс зүйн дүрэм, журмаар зохицуулж байгаа хууль, тогтоомж, дүрэм, журамд нэмэлт өөрчлөлт оруулах чиглэлээр судалгаа хийж, санал боловсруулж, шийдвэрлүүлэх.

#### **Хүрэх үр дүн:**

1. Ёс зүйн дэд хороодын ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хамтын ажиллагаа сайжирч, ёс зүйн зөрчлийн тохиолдолд тулгуурласан сургалтын агуулгын хүрээ өргөжсөн, ёс зүйн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн уялдаа холбоо сайжирсан байна.

**Стратегийн зорилт 3.2. Ёс зүйн хэм хэмжээг сахиулах, сургалтыг тогтмолжуулж, соён гэгээрүүлэх, нөлөөллийн ажлыг нэмэгдүүлнэ.**

#### **Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

1. Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтын батлагдсан агуулгын дагуу үндэсний сургагч багшийг бэлтгэж, сургалтыг тогтмолжуулах;

2. Төрийн өндөр, улс төрийн, томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайллыг сайжруулах чиглэлээр зорилтот бүлэг бүрээр сургалт, нөлөөллийн ажлыг өргөжүүлэх;

3. Үндэсний үнэт зүйл, онцлогийг хадгалсан, олон улсын ёс зүйн зарчимд нийцсэн сургалт, нөлөөллийн ажлыг үе шаттай зохион байгуулж, байгууллага, албан хаагчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө, удирдлагаар хангаж ажиллана.

#### **Хүрэх үр дүн:**

1. Төрийн албаны бүх шатанд ёс зүйн манлайлал, үлгэрлэл, соёл сайжирч, сайн дураар ёс зүйн хариуцлага хүлээдэг жишиг тогтож, хандлага нэмэгдсэн байна.

**Стратегийн зорилго 4: Ёс зүй, сахилга хариуцлага хэвшсэн, олон нийтийн итгэлийг хүлээсэн байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.**

**Стратегийн зорилт 4.1. Байгууллагын үйл ажиллагаанд технологийн шийдлүүдийг нэвтрүүлж, бие даасан байдлыг нэмэгдүүлэн, олон нийтэд нээлттэй, ил тод үйл ажиллагааг хэвшүүлнэ.**

#### **Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

1. Байгууллагын үйл ажиллагааг иргэдэд, нээлттэй, хүртээмжтэй хүргэж, олон нийтийн оролцоонд тулгуурлан үр дүнтэй хяналтыг бий болгох;

2. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллаж, хүний эрхийг дээдэлсэн, жендэрийн мэдрэмжтэй бодлого, шийдвэрүүдийг гарган хэрэгжүүлэх;

3. Гадаад, дотоодын байгууллагуудтай хамтын ажиллагаа түншлэлийг өргөжүүлж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн олон улсын туршлагаас суралцах;

**Стратегийн зорилт 4.2. Албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулж, мэргэшсэн, хариуцлагатай, суралцагч байх хүний нөөцийн бодлого хэрэгжүүлнэ.**

**Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

1. Хүний нөөцийн хөгжлийг дэмжсэн суралцагч байгууллага байж, сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөр хэрэгжүүлж, албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах;

2. Төрийн албаны чадамжийн хүрээнд удирдан зохион байгуулах, дүн шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх, манлайлах, багаар ажиллах, албан хэргийг гадаад хэл дээр чөлөөтэй явуулах ур чадварыг дээшлүүлж, үр дүнг тооцож ажиллах;

3. Албан хаагчид өөр хоорондоо мэдлэг, туршлагаа хуваалцах, харилцан суралцах боломжийг бүрдүүлж, хамтран ажиллах соёлыг хөгжүүлэх.

**Хүрэх үр дүн:**

1. Чадварлаг, мэргэшсэн хүний нөөцөөр дэмжигдсэн, гадаад, дотоод хамтын ажиллагаа өргөжин, байгууллагын үйл ажиллагаа иргэдэд ил тод, хүртээмжтэй болж, олон нийтийн оролцоо, хяналт сайжирсан байна.

---oOo---